

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН 2017 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр.

№	Хөтөлбөрийн зорилт	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа /ХХААХҮЯ-наас төлөвлөсөн/	Гүйцэтгэл
1.	Зорилт 1. шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх;	Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянуулж, томилох	2017 онд шинээр томилогдохоор нэр дэвшсэн 41 этгээдийн ХАСУМ-ийг хянуулж, 29 албан хаагчийг томиллоо.
2.	сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон	ХАСУМ-ийг хянуулахдаа Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлтийг хүргүүлж хэвшүүлэх.	2017 оны 12 дугаар сараас ХАСУМ-ийг хянуулахдаа ТАЗ-ийн нөөцөд байгаа эсвэл Төрийн албан хаагчийн тангарагийн хуудсыг нотлох баримт болгон хавсарган хүргүүлж, цаашид хэвшүүлэхээр ажиллаж байна.
3.	томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх;	Төрийн захиргааны төв байгууллагын хүний нөөцийн жагсаалт, төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэлийг ил тод, нээлттэй болгох	Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт, чөлөөлөгдсөн албан албан хаагчийн тоон мэдээллийг <a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> цахим хуудсанд сар бүр байршуулж байна. Ажлаас чөлөөлөгдсөн, ажилд шинээр томилогдсон албан хаагчдын мэдээллийг тухай бүр нь дотоод сүлжээнд байршуулж, мэдээлж байна.
4.		Албан хаагчдад тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн төрийн албанд томилохоор дэвшүүлэх	Тухайн албан тушаалын ажлын байрны тодорхойлолтод заасан шаардлагыг хангаж байгаа албан хаагчийг томилох саналыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлж, нэр дэвшүүлэх дүгнэлт гаргуулан томилж байна.
5.		Төрийн захиргааны албан хаагчийг сэлгэн ажиллуулах	Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Тэжээвэр амьтны асуудал хариуцсан ахлах мэргэжилтэнг тус газрын Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтнээр сэлгэн томилсон.
6.		Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийг мөрдүүлэх, яамны цахим хуудаст болон дотоод сүлжээгээр дамжуулан албан хаагчдад танилцуулах	Яамны цахим хуудас <a href="http://www.mofa.mn">www.mofa.mn</a> -ны “Хүний нөөц” буланд Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм, төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн тухай зөвлөмж, гарын авлага байрлуулснаар ёс зүйн тухай ойлголт, мэдээлэл авах боломж нөхцлөөр хангалаа. Мөн Ёс зүйн хорооны хуралдаанаар хэлэлцсэн асуудлын тоймыг байршуулав. Мөн цахим хуудасны “Хүний нөөц” буланд иргэдээс “Төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлагын талаар санал, хүсэлт хүлээн авах” буланг ажиллуулж, байгууллагын 1 давхарт байрлах Авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчлах мэдээллийн самбарын дэргэд иргэдийн санал, хүсэлтийг хүлээж авах “Саналын хайрцаг” ажиллуулж байна.

7.		Байгууллагын Ёс зүйн хороог байгуулан ажиллуулж, шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, тайлагнах,	2017 онд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Ёс зүйн хорооны хуралдаанаар “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа зохион байгуулах тухай” хэлэлцэж, яам болон харьяа байгууллагын нийт албан хаагчдад “Төрийн албан хаагчдын эрхэмлэн дагаж мөрдөх есөн зүйл”-ийг чанд мөрдөж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх ажлыг зохион байгуулав. Одоогоор ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн албан хаагч байхгүй.
8.		Өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор саналын хайрцаг болон ХХААХҮЯ-ны цахим хуудаст булан ажиллуулах	- Яамны цахим хуудас <a href="http://www.mofa.gov.mn">www.mofa.gov.mn</a> -г “Өргөдөл, гомдол” булан нээж, өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтний нэр, утасны дугаар, цахим хаягийг ил байршуулан, иргэдийн санал хүсэлт, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч, шийдвэрлэж байна. - Яамны 1 дүгээр давхарт, Авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчлах мэдээллийн самбарын дэргэд иргэдийн санал хүсэлтийг авах “Санал хүсэлт” хайрцаг ажиллуулж байна. - ХХААХҮЯ-ны дэргэд “Малчдын лавлах” - 109 утсыг ажиллуулж, алдсан, олдсон малын талаарх мэдээллийг авч, иргэдэд мэдээлж байна.
9.		Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлтийн шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг ХХААХҮЯ-ны цахим хуудаст тогтмол хугацаанд мэдээлэх	Яамны цахим <a href="http://www.mofa.gov.mn">www.mofa.gov.mn</a> хуудаст “Өргөдөл, гомдол” булан нээж, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч, өргөдөл, гомдол, хүсэлтийн шийдвэрлэлтийн мэдээг хагас, бүтэн жилээр нэгтгэн гаргаж байршуулан олон нийтэд мэдээлж байна. - 2017 онд тус яаманд нийт 323 өргөдөл, 11-11 төвд хандсан 94 санал хүсэлт, яамны цахим хаягаар 8 санал, хүсэлт хүлээн авч, хариуг хуулийн хугацаанд нь хүргүүлж ажиллаа. - Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоолын дагуу өргөдөл, гомдол, санал хүсэлтийн шийдвэрлэлтийн мэдээг ЗГХЭГ-т хүргүүлэн ажиллаж байна.
10.		АТГ-аас ирүүлсэн зөвлөмжийн дагуу Хууль бус шийдвэрийг хүчингүй болгох	Авлигатай тэмцэх газрын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн Зөвлөмжийг хэрэгжүүлж, “Урамшуулал олгох тухай” ХХААХҮЯ-ны ТНБД-ын 2016 оны 05 сарын 30-ны өдрийн А-232 дугаар тушаалыг ТНБД-ын 2017 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А-516 дугаар тушаалар хүчингүй болгов.
11.		Яамны төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах төлөвлөгөөг батлуулж мөрдүүлэх.	Яам болон харьяа байгууллагын төрийн албан хаагчдын дунд 2017 онд зохион байгуулах сургалт, мэдээллийн цагийн төлөвлөгөөг Төрийн захиргааны удирдлагын газрын даргаар батлуулж, мэргэшүүлэх, мэдээлэл өгөх, шинээр батлагдсан хууль, тогтоомж танилцуулах зэрэг 18 сургалт, мэдээллийн цагийг зохион байгуулав.

12.	Зорилт 2. төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж чанар хүртээмжийг нь сайжруулах,	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ буюу Хэрэглэгчийн үнэлгээ хийлгүүлэх.	"Хэрэглэгчийн үнэлгээ хийх" тендерт шалгарсан "Улаанбаатар аудит корпораци" ХХК-ийн судалгааны үр дүнгээр 2017 онд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хэрэглэгчийн ерөнхий үнэлгээ 86.8 хувьтай байгаа нь салбарын хэрэглэгчдийн сэтгэл ханамж өндөр байгааг илтгэж байна.
13.	үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх;	Байгууллагын хэмжээнд төрийн албан хаагчдын хариуцлагыг дээшлүүлэх, урьдчилан сэргийлэх	<p>- Төрийн албан хаагчдын ажлын цаг ашиглалт, бүтээмж, үр дүнг сайжруулах ажлын хүрээнд албан хаагчдын цаг ашиглалтад хяналт тавих үүрэг бүхий Ажлын хэсгийг ТНБД-ын 2017 оны А-465 дугаар тушаалаар байгуулж, яам болон харьяа байгууллагын албан хаагчдын цаг ашиглалтад хяналт тавьж, тайланг удирдлагын Шуурхай хуралдаанд танилцуулж ажиллаа. Албан хаагчид албан ажлаар гадуур явсан тухайгаа Гадуур ажлын дэвтэрт тэмдэглэл хийгээгүй, чөлөөний хуудас бичээгүй чөлөө авсан зэрэг нийтлэг дутагдлыг илрүүлж, зөрчлийг арилгах талаар ТНБД-ын зүгээс удирдлагуудад үүрэг өгч, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.</p> <p>- Төрийн албан хаагч үйл ажиллагаандаа хууль дээдлэх, шударга ёсыг ханган, албан үүргээ гүйцэтгэхдээ хэрхэн ёс суртахуунтай ажиллаж байгаа талаар тус яамаар 2017 оны 12 дугаар сарын эхний 7 хоногт үйлчлүүлсэн иргэдээс асуулга авч дүгнэлээ. Судалгаанд нийт 44 иргэд хамрагдсан байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Ажлын цаг ашиглалтын талаар: Уулзаж, мэдээлэл авахыг хүссэн ажилтан ажлын байрандаа байсан гэж 37 иргэн буюу судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 84,0 хувь нь хариулсан байна.</li> <li>2. Ил тод, шударга байдлын талаар: Хүссэн мэдээллээ авч, сэтгэл ханамжтай байгаагаа 39 иргэн буюу судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 88,6 хувь нь илэрхийлсэн байна.</li> <li>3. Хүнд суртал, ёс зүй, зан харилцааны талаар: Ажилтан ямар нэгэн зөрчил гаргаагүй талаар 36 иргэн буюу судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 81,8 хувь нь мэдэгдсэн байна.</li> <li>4. Авилга, ашиг сонирхлын зөрчлийн талаар: Ажилтан шан харамж, мөнгө, бэлэг дурсгалын зүйл аваагүй, өгөхийг шаардаагүй гэж 40 иргэн буюу судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 90,9 хувь нь мэдэгдсэн байна.</li> </ol>
14.	Зорилт 3. төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу	Төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, зарцуулалтын байдалд дүн шинжилгээ хийж, хариуцлагыг дээшлүүлэх	ТНБД-ын 2016 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн А-95 дугаар тушаалаар байгууллагын Өмч хамгаалалах байнгын зөвлөлийг шинэчлэн байгуулж, 2017 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн А-250 дугаар тушаалр Эргэлтийн хөрөнгийн тооллого явуулах байнгын ажлын хэсгийг шинээр томилон ажиллуулж байна. Мөн хагас жил, жилийн эцсийн байдлаар эд хөрөнгийн тооллого явуулах Ажлын хэсгийг тухай бүр томилон ажлуулж, тайланг удирдлагад

	зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх;		танилцуулан Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, саналыг холбогдох байгууллагал хүргүүлэн шийдвэрлүүлж байна.
15.		“Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, түүний хавсралт болон дэд цэсүүдэд тавигдсан мэдээллийг цаг тухайд нь хөтлөх.	Шилэн дансны <a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> цахим хуудаст мэдээллийг тогтмол байршуулж байна. Тус яаман дээр Үндэсний аудитын газраас 2017 оны 11 дүгээр сард Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн байдалд аудит хийсэн. Одоогоор дүгнэлт ирүүлээгүй байна. Санхүүгийн дотоод аудит хариуцсан мэргэжилтэн дотоод хяналтыг тавьж, дүнг Төсвийн ерөнхийлөн захирагч дэргэдэх Дотоод аудитын хороонд танилцуулж, ажиллаж байна.
16.		Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтын мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд “Засгийн газрын тусгай сангийн мэдээлэл” гэсэн цэсээр олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулах	Шилэн дансны <a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> цахим хуудаст мэдээллийг тогтмол байршуулж байна. Тус яаман дээр Үндэсний аудитын газраас 2017 оны 11 дүгээр сард Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн байдалд аудит хийсэн. Одоогоор дүгнэлт ирүүлээгүй байна. Санхүүгийн дотоод аудит хариуцсан мэргэжилтэн дотоод хяналтыг тавьж, дүнг Төсвийн ерөнхийлөн захирагч дэргэдэх Дотоод аудитын хороонд танилцуулж, ажиллаж байна.
17.		Тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах, иргэд олон нийтийн зүгээс хяналт тавих боломжтой байх зорилгоор цахим хуудсыг нээн ажилуулах.	Яамны харьяа Тариалан эрхлэлтийг дэмжих сан <a href="http://www.teds.mn">www.teds.mn</a> цахим хуудас, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан <a href="http://www.smefund.gov.mn">www.smefund.gov.mn</a> цахим хуудас, Мал хамгаалах сан <a href="http://www.mxc.gov.mn">www.mxc.gov.mn</a> цахим хуудсыг тус тус ажиллуулж, үйл ажиллагаагаа сурталчлан, иргэдэд шаардлагатай мэдээ, мэдээллийг түгээж байна.
18.		Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн дотоод аудитын хяналтын хараат бус байдлыг хангаж, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох	Санхүүгийн дотоод аудитын хараат бус байдлыг хангах ажлын хүрээнд Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх дотоод аудитуудад Төсвийн тухай хуулийн 69.4 дэх заалтын хүрээнд шаардлага хангасан дотоод аудитуудад санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн эрхийг олгуулах ажлыг зохион байгуулж, Сангийн сайд бөгөөд Санхүүгийн хяналт шалгалтын ерөнхий байцаагчийн шийдвэрээр Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн 2, Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн 1 эрхийг ХХААХҮ-ийн салбарын аудитуудад олгуулсан. Санхүүгийн хяналт шалгалтын улсын /ахлах/ байцаагчийн эрхтэй аудитууд нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 4.1.2. дэх заалтын дагуу дотоод аудит, хяналт шалгалтыг явуулахдаа хараат бус, шударга, хяналт шалгалтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын үйл ажиллагаа нээлттэй, ил тод байх зарчмыг баримтлан ажиллаж, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1. дэх заалтын дагуу хяналт, шалгалт хийхдээ ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргаж ажиллаж байна. Мөн Засгийн газрын 2015

			оны 483 тогтоолоор батлагдсан Дотоод аудитын дүрмийн 4.12. дэх заалтын хүрээнд Төсвийн ерөнхийлөн захирагч дэргэдэх "Дотоод аудитын хороо"-г 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулж, дотоод аудит, хяналт шалгалтын ажлын дүнг Дотоод аудитын хороогоор хэлэлцүүлж, хорооны тогтоол гаргуулан, биелэлтэд хяналт тавьж ажиллаж байна.
19.		Аудитын байгууллагын акт, дүгнэлтийг байгууллагын цахим хуудаст байршуулж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Яамны цахим <a href="http://www.mofa.gov.mn">www.mofa.gov.mn</a> хуудаст хуулийн хугацаанд нь байршуулж байна.
20.	Зорилт 7. авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих;	Шийдвэр гаргах шатанд иргэний нийгмийн оролцоо, хяналтын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийх ажлыг төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах	Хууль, тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг тогтоох судалгааг тус яамны Хуулийн хэлтсийн салбар хариуцсан эрх зүйч нар хийж байна.
21.		Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бүрдүүлэх	2017 онд тендер сонгон шалгаруулалт зохион байгуулсан 8 ажлын хэсэгт 11 төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулав.
22.		Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, төсвөөс олгож байгаа санхүүжилтийн зарцуулалтыг ил тод, нээлттэй болгож нийтэд мэдээлэх	ХХААХҮ-ийн салбарт үйл ажиллагаагаа эрхэлж, тус яамтай тогтмол хамтын ажиллагаатай 83 мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллага байгаагаас 2017 онд 12 мэргэжлийн холбоо, ТББ-аар сургалт, семинар үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, судалгаа хийлгэх, ном хэвлүүлэх ажлыг гүйцэтгүүлж, бодлогын баримт бичиг боловсруулах ажлын хэсэгт оруулж хамтран ажиллаа.
23.		Яам, агентлагийн дэргэд авлигаас урьдчилан сэргийлэх олон нийтийн хяналтын дэд зөвлөлтэй хамтран ажиллах.	2017 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр ХХААХҮЯ-ны ТНБД, АТГ-ын ХШДШХ-ийн дарга, яамны дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн гишүүдийн хооронд Хамтран ажиллах гэрээг байгуулсан. Олон нийтийн зөвлөлийн гишүүдийг тухай бүр хүлээн авч уулзан, харилцан мэдээлэл солилцож ажиллаа.
24.	Зорилт 10. шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх;	Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор албан хаагчдад зориулсан сургалт, сургалчилгааны ажлыг зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> <li>- Зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор яамны цахим хуудаст <a href="http://www.mofa.gov.mn">www.mofa.gov.mn</a> “Авлигын эсрэг, ХАСХОМ” булан, мөн байгууллагын дотоод сүлжээнд “Авлигын эсрэг үйл ажиллагаа” буланг тус тус нээн ажиллуулж, ХАСХОМ мэдүүлэх заавар, зөвлөмж, маягтууд, сургалтын материал, авлигын хууль, тогтоомжийн тухай түгээмэл асуулт, хариулт зэрэг мэдээллийг байршуулсан.</li> <li>- АТГ-тай хамтран 2017 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр Мэдүүлэг гаргагч нарт зориулсан сургалтыг яамны албан хаагчдын дунд зохион байгуулсан.</li> <li>- АТГ-аас эрхлэн гаргасан “Мэдүүлэг гаргагч нарт зориулсан гарын авлага”-ыг 97 албан хаагчдад түгээгээд байна.</li> </ul>

		<p>- 2017 оны 01 сарын 12-нд зохион байгуулсан Салбарын удирдах ажилтны зөвлөгөөний үеэр аймгуудын ХХААГ-ын дарга нарын дунд “Төрийн албан хаагчийн ёс зүй”, “Захиргааны ерөнхий хууль”, “Төрийн албаны стандарт, зохицуулалт, харилцаа, ажлын байрны тодорхойлолт” сэдвээр цогц сургалт зохион байгуулж, мөн гарын авлагаар хангав.</p> <p>- Аймгуудын ХХААГ болон Сумдын мал эмнэлэг, үржлийн тасгийн албан хаагчдыг чадавхжуулах, мэдээлэл солилцох зорилгоор 2017 оны 8, 9 дүгээр сард салбарын хэмжээнд нэгдсэн арга хэмжээг бүсчилэн зохион байгууллаа. Арга хэмжээний үеэр “Төрийн албан хаагчийн ёс зүй, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сургалтыг зохион байгуулж 21 аймгийн болон нийслэлийн нийт 900 гаруй албан хаагчдыг хамруулсан.</p> <p>- 2017 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр Удирдлагын академийн багш, доктор, дэд профессор Н.Цолмонтаятай хамтран яамны төрийн албан хаагчдын дунд "Төрийн албан хаагчийн харилцааны ёс зүй" сэдэвт сургалтыг зохион байгуулав.</p> <p>- Яамны 1 дүгээр давхарт, ил харагдахуйц байрлалд Авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчлах мэдээллийн самбар ажиллуулж байна.</p>
25.	Төрийн байгууллагуудын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, байгууллагын цахим хуудаст байршуулж, хэрэгжилтийн үр дүнг сайжруулах	2017 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан АТГ-аас санал авахаар цахимаар хүргүүлсэн боловч, хариу ирүүлээгүй. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын хүрээнд байгууллагын хэмжээнд зохион байгуулах арга хэмжээг төлөвлөн ажиллаа.
	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	Ололт:
		Төрийн албан хаагчдын мөрдөж байгаа зарим дүрэм, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар оновчтой, боловсронгуй болгохоор тусгасан байна.
		Анхаарах асуудлууд:
		-
	Санал:	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд ХХААХҮЯ үндсэн хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээ байхгүй бөгөөд цаашид хөтөлбөрийн хүрээнд төрийн бүх шатны байгууллагууд хэрэгжүүлэхээр заасан үйл ажиллагааны хэрэгжилтийг хангаж ажиллана.
	Шаардагдах төсөв	-
	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлагдсан эхний жил 2017 онд хөтөлбөрийг таниулан, сурталчлах ажлын хүрээнд АТГ-тай хамтран ажиллаа.
	Сургалтад хамруулах албан хаагчийн тоо	Нийт 135 ХАСХОМ мэдүүлэгч байгаа бөгөөд үүнээс шинээр мэдүүлэгч 21 албан хаагч байна.